



2018 оны 10 дугаар сарын 08
№37/1042/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Үндэсний хөтөлбөр
батлах тухай**

**Монгол Улсын
Үндсэн хуулийн
цэцийн дүгнэлт**

**Монгол Улсын Их Хурлын
2018 оны 62 дугаар тогтоол
Үндсэн хуулийн холбогдох
заалтыг зөрчсөн эсэх маргааныг
хянан шийдвэрлэсэн тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

346.	Үндэсний хөтөлбөр батлах тухай	Дугаар 144	1137
347.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 145	1151

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

348.	Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 10	1161
------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------	------

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 5 дугаар сарын 23-ны өдөр	Дугаар 144	Улаанбаатар хот
------------------------------------	------------	-----------------

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-т заасныг үндэслэн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.10-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Нэг иргэн-нэг бүртгэл” үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ



Засгийн газрын 2018 оны 144 дүгээр
тогтоолын хавсралт

“НЭГ ИРГЭН-НЭГ БҮРТГЭЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны н-27/18 дугаар зөвлөмж, Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого (2017-2025) зэрэг бодлогын баримт бичгүүдэд “Улсын бүртгэлийн үйл ажиллагааг онлайн горимд шилжүүлж, үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх”, “Улсын бүртгэлийн эх нотлох баримтыг бүхэлд нь цахимжуулах”, “Нэг иргэн-нэг бүртгэл” хөтөлбөр хэрэгжүүлэх замаар бүртгэлийн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн болон цахим бизнес, онлайн банкны үйлчилгээг жигд, тэгш авах нөхцөлийг бүрдүүлэх, “хууль зүйн салбарын байгууллагуудын хүний нөөц, техник тоног төхөөрөмж, дэд бүтцийг шинэчлэн, хуульд заасан үүргээ стандартын дагуу хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх”, “төрийн ой санамж болох улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгох” гэсэн зорилтуудыг тус тус хэрэгжүүлэхээр тусгасан.

Улсын бүртгэлийн байгууллага нь иргэний бүртгэлийн 19, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 29, хуулийн этгээдийн бүртгэлийн 10, архивын 28, нийт 86 төрлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үзүүлдэг. Иргэнд суурилсан улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэн, хуулийн этгээдийн эрхийг хангах, төрийн ой санамжийг бүрдүүлэх, бэхжүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай болгож, бүртгэлийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэхэд дараахь тулгамдсан асуудлууд байна. Үүнд:

-улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд 67 хороо, 303 сум холбогдоогүй;

-төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох байдал хязгаарлагдмал, мэдээлэл зөрүүтэй, улсын бүртгэл хөтлөхөд шаардлагатай мэдээллийг төрийн байгууллагуудын мэдээллийн сангаас авах боломж бүрдээгүй;

-улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн тоног төхөөрөмж, програм хангамжийг сайжруулахад хөрөнгө оруулалт дутагдалтай, шинэчлэх ажлууд үе шаттайгаар хийгдэлгүй явж ирснээс улсын бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах боломжгүй нөхцөл үүсч,

техник тоног төхөөрөмжөөс шалтгаалсан саатал удаа дараа гарч байна. Тухайлбал, бүртгэлийн байгууллага үйл ажиллагаандаа өгөгдөл хадгалах зориулалт бүхий нийт 67 сервер, 8 хадгалах төхөөрөмж, 4531 ширхэг компьютер, дагалдах тоног төхөөрөмж ашиглаж байгаагаас 48 сервер (71.6 хувь), 8 хадгалах төхөөрөмж, компьютер, дагалдах тоног төхөөрөмжийн 85 хувь нь ашиглалтын хугацаа хэтэрсэн;

-мэдээллийн сан удирдах системүүд програмын лицензийн хугацаа дууссанаас мэдээллийн санд гэмтэл саатал гарах үед мэргэжлийн байгууллагаас тусламж авах, цаашид шинэчлэгдсэн хувилбарыг ашиглах боломжгүй;

-мэдээллийн сангуудыг нөөцлөх тоног төхөөрөмжийн багтаамж дүүрсэн;

-улсын хэмжээнд бүртгэлийн архив 32 нэгжид байршиж байгаа бөгөөд Улсын бүртгэлийн төв архив, нийслэл, 13 аймаг, 8 дүүргийн бүртгэлийн нэгжүүд архивын зориулалтын байргүй, өрөөний хүрэлцээгүйгээс шалтгаалан архивын материалыг хонгилын давхар, автомашины гражид хадгалж байгаа нь архивын баримт хадгалах орчны стандарт шаардлагыг хангахгүй, улсын бүртгэлийн эх нотлох баримт бүхий архив гэмтэх, устах өндөр эрсдэлтэй болсон;

-засаг захиргааны нэгжид суурилсан хаягжилт нь нэгдсэн стандарт системгүй, ойлгомжгүй байгаа нь орчин үеийн бизнесийн болон төрийн үйлчилгээний шаардлага хангахгүй байгаа;

-улсын бүртгэлийн эх нотлох баримт бүрэн цахимжаагүй, цахимжсан зарим төрлийн баримтад нэмэлт, баяжилт хийгдээгүйгээс үйлчилгээнд бүрэн ашиглах боломжгүй байгаа;

-улсын бүртгэлийн байгууллагаас гаргасан тоон мэдээллээр 2017 онд иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн 271694¹ лавлагааг биечлэн, үйлчилгээний ТҮЦ машинаар 1.5 сая лавлагааг олгосон нь иргэд төдийгүй бүртгэлийн байгууллагад ажлын ачаалал, зардал нэмэгдүүлэх үндсэн шалтгаан болдог зэрэг эрсдэл, хүндрэл үүсч байна.

Иймд иргэнд суурилсан нэг эх сурвалж бүхий суурь мэдээллийн сан бүрдүүлэх, чанарыг сайжруулах, цахим сүлжээний нууцлал, аюулгүй байдал, хэвийн найдвартай ажиллагааг хангах тоног төхөөрөмж, програм хангамжийг шинэчлэх, бүртгэлийн байгууллагын салбар, нэгжийг нэгдсэн сүлжээнд холбон иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран цахим хэлбэрээр хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх,

¹Бүртгэлийн байгууллагын захиргааны статистикийн мэдээлэл



суурь мэдээллийг бусад байгууллагатай солилцох болон газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн санг бий болгох асуудлыг цогцоор нь үе шаттайгаар шийдвэрлэх шаардлагатай байна.

Улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цаашид цахимжуулах ажлыг үргэлжлүүлж хэрэглээнд нэвтрүүлэх боломжийг бий болгосноор улсын бүртгэлийг цахимаар хөтлөх боломж бүрдэх юм.

Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн хадгалалт, хамгаалалт, цахим сүлжээний хэвийн ажиллагааг хангах, мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглан төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд нээлттэй, хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, иргэний үнэмлэхийн цахим санах ойд тоон гарын үсэг суурилуулан төрийн болон төрийн бус байгууллагаас үйлчилгээ авах, хэрэглээг нэмэгдүүлэх, Монгол Улсад хаягийн нэг стандарт, нэгдсэн санг бий болгох, түүнд суурилсан бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх зэрэг шаардлагыг үндэслэн “Нэг иргэн-нэг бүртгэл” хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо үе шаттай төгөлдөржүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, эх нотлох баримтыг бүрэн цахимжуулж, цахим хэрэглээг нэмэгдүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, төрийн ой санамжийг бэхжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

Зорилт 1. бүртгэлийн байгууллагын хэмжээнд ашиглаж байгаа техник, тоног төхөөрөмж, програм хангамжийг шинэчлэх, сайжруулах;

Зорилт 2. архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж, эх нотлох баримтыг бүрэн цахимжуулах;

Зорилт 3. дэд бүтцийг шинэчлэн зохион байгуулж, иргэний бичиг баримтын үйлдвэрийг өргөтгөх;

Зорилт 4. иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн мэдээллийн сангийн чанар, багтаамжийг сайжруулах, нэгдсэн удирдлага бүхий систем бий болгох;

Зорилт 5. газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн сан бий болгох;



Зорилт 6. бүртгэлийн байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлж, чадавхижуулах;

Зорилт 7. тоон гарын үсгийг иргэний үнэмлэхийн цахим санах ойд суурилуулж, иргэний үнэмлэхийн хэрэглээний төрлийг нэмэгдүүлэх;

Зорилт 8. улсын бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэд төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй авах нөхцөлийг бүрдүүлэх;

Зорилт 9. төрийн болон төрийн бус байгууллагуудтай мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэх.

2.3. Хөтөлбөр хэрэгжих хугацаа:

Хөтөлбөрийг 2018-2021 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн програм хангамжийг шинэчлэх, сайжруулах;

3.1.2. мэдээллийн сангийн нөөцлөлтийг автомат горимоор хийх, мэдээллийн санг хянах програм хангамж боловсруулах, хэрэглээнд нэвтрүүлэх;

3.1.3. бүртгэлийн системд ашиглаж байгаа сервер, компьютер, тоног төхөөрөмжийг шинэчлэх;

3.1.4. сүлжээний нууцлал аюулгүй байдлыг ханган, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

3.1.5. бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбогдоогүй анхан шатны нэгж болох хороо, сумдыг улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбох;

3.1.6. эрчим хүчний өндөр зэрэглэлд хамруулах, нөөц эх үүсвэртэй болох.

3.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



3.2.1. стандартын шаардлага хангасан архивын нэгдсэн байртай болгох;

3.2.2. эх нотлох баримтыг цахимжуулахад шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, орчныг бүрдүүлэх;

3.2.3. иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн эх нотлох баримтыг бүрэн цахимжуулж дуусгах.

3.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. Монгол Улсын иргэний үнэмлэхийн нууцлал бүхий бэлдэц, бичилтийг хийх, үндэсний энгийн цахим гадаад паспорт үйлдвэрлэх, болон паспортад бичилт хийх хүчин чадалтай дотоодын үйлдвэр байгуулах;

3.3.2. иргэний үнэмлэхийн бэлдэц бэлтгэх тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл худалдан авах;

3.3.3. иргэний үнэмлэхийн хэвлэх үйлдвэрийн байрыг өргөтгөх;

3.3.4. үндэсний цахим гадаад паспортад бичилт хийх нөхцөл бүрдүүлэх. (дотоод)

3.4. Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1. иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангийн чанар, багтаамжийг сайжруулах;

3.4.2. засаг захиргааны нэгжийн кодчиллол болон нэршлийг нэгдсэн стандартад оруулах;

3.4.3. бүртгэл тус бүрээр салангид байгаа мэдээллийн сангуудын нэгдсэн удирдлагыг бий болгох.

3.5. Хөтөлбөрийн 5 дугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.5.1. төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд хамтран хаягийн шинэчилсэн бүртгэлийн мэдээллийн санг бий болгох ажлыг зохион байгуулах;

3.5.2. газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн санг бий болгож, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн хаягийг шинэчлэн бүртгэх;

3.5.3. эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн систем дэх газрын нэгж талбарын дугаарыг газрын кадастрын суурь мэдээллийн сантай холбож, ашиглахтай уялдуулах;

3.5.4. улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн иргэний оршин суугаа хаягийг иргэний үнэмлэхийн цахим санах ойд бичих ажлыг зохион байгуулах.

3.6. Хөтөлбөрийн 6 дугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.6.1. дэвшилтэт технологийн шаардлагад нийцүүлэн бүртгэлийн байгууллагын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах, чадавхижуулах;

3.6.2. бүртгэлийн анхан шатны нэгжүүдийг мэргэшсэн, ур чадвар бүхий боловсон хүчнээр хангах;

3.6.3. мэдээллийн технологийн албан хаагчдыг мэргэшүүлэх, тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бий болгох.

3.7. Хөтөлбөрийн 7 дугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.7.1. тоон гарын үсгийг иргэний үнэмлэхийн цахим санах ойд суурилуулж олгох зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.7.2. шинээр хэвлэгдэх иргэний үнэмлэхийн цахим санах ойд тоон гарын үсгийн түлхүүрийн хослолыг үүсгэх, карт хэвлэх системийн програм хангамжийг боловсруулах, үйлчилгээнд нэвтрүүлэх;

3.7.3. иргэдэд олгогдсон иргэний үнэмлэхэд тоон гарын үсэг бичих боломжийг бүрдүүлэхийн тулд 2048 бит түлхүүрийн хослолыг бичих програм хангамжийг боловсруулах, үйлчилгээнд нэвтрүүлэх;

3.7.4. иргэний үнэмлэхийн цахим санах ойд тусгагдсан тоон гарын үсгийн мэдээллийг таних програм боловсруулах, үйлчилгээнд нэвтрүүлэх;

3.7.5. бүртгэлийн анхан шатны нэгжээр дамжуулан иргэдэд тоон гарын үсгийг олгож, үйлчилгээнд нэвтрүүлэх.



3.8. Хөтөлбөрийн 8 дугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.8.1. иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийг цахимаар хөтлөх системийг боловсруулах, ашиглах;

3.8.2. улсын бүртгэлийн лавлагаа, үйлчилгээг иргэн, хуулийн этгээд цахимаар шуурхай, хүртээмжтэй авах нөхцөлийг бүрдүүлэх;

3.8.3. төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн мэдээлэл солилцох ажлыг сайжруулж, бүртгэлийн үнэн зөв, шуурхай байдлыг хангах.

3.9. Хөтөлбөрийн 9 дүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.9.1. бүртгэлийн байгууллагын мэдээллийг нээлттэй, шаардлагатай тохиолдолд тодорхой хязгаартай ашиглуулах боломжийг бүрдүүлэх;

3.9.2. Засгийн газраас баталсан төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журмын хэрэгжилтийг хангаж, иргэн, төрийн болон төрийн бус байгууллагуудад шаардагдах мэдээллийг нийлүүлэх;

3.9.3. улсын бүртгэл хөтлөхөд шаардагдах мэдээллийг төрийн болон төрийн бус байгууллагуудаас авч үйлчилгээнд ашиглах.

Дөрөв. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

4.1.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтыг хэрэгжүүлснээр бүртгэлийн байгууллагад ашиглаж байгаа техник, тоног төхөөрөмж, програм хангамж шинэчлэгдэж орчин үеийн технологийн чиг хандлагад нийцсэн шинэ технологи нэвтрүүлсэн байна.

4.1.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтыг хэрэгжүүлснээр эх нотлох баримтыг бүрэн цахимжуулж, архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт стандарт түвшинд хүрч, мэдээллийн аюулгүй байдлын зорилт хангагдана.

4.1.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтыг хэрэгжүүлснээр Улсын бүртгэлийн дэд бүтцийг шинэчлэн зохион байгуулж, иргэний бичиг баримтын үйлдвэрийг өргөтгөснөөр төрөөс олгож байгаа баримт бичгийн болон иргэний мэдээллийн нууцлал, аюулгүй байдал хангагдана.



4.1.4. Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтыг хэрэгжүүлснээр улсын бүртгэлийн мэдээллийн сан нэгдсэн удирдлагатай болж, суурь мэдээллийн сангийн үнэн зөв, найдвартай байдал бий болсон байна.

4.1.5. Хөтөлбөрийн 5 дугаар зорилтыг хэрэгжүүлснээр газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн санд иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хаягийн сан холбогдож, улсын хэмжээнд хаягийн нэгдсэн стандартад шилжсэн байна.

4.1.6. Хөтөлбөрийн 6 дугаар зорилтыг хэрэгжүүлснээр бүртгэлийн байгууллагын хүний нөөцийн мэдлэг, ур чадвар дээшилж, бүртгэлийн үйл ажиллагаа сайжирч, мэргэшсэн хүний нөөц бүрдсэн байна.

4.1.7. Хөтөлбөрийн 7 дугаар зорилтыг хэрэгжүүлснээр тоон гарын үсгийг иргэний үнэмлэхийн цахим санах ойд суурилуулж, цахим орчинд иргэнийг таних нөхцөл бүрдсэн байна.

4.1.8. Хөтөлбөрийн 8 дугаар зорилтыг хэрэгжүүлснээр улсын бүртгэлийг цахимаар хөтлөх боломжийг бүрдүүлж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран шуурхай, хүртээмжтэй болгоно.

4.1.9. Хөтөлбөрийн 9 дүгээр зорилтыг хэрэгжүүлснээр улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд суурилсан иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн мэдээллийг төрийн болон төрийн бус байгууллагатай солилцох замаар мэдээллийн зөрүүг арилгах, үйлчилгээний шуурхай байдал хангагдсан байна.

Тав. Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт

5.1. Хөтөлбөрийн нийгэмд үзүүлэх үр нөлөө:

5.1.1. Иргэд хаана байгаагаас үл хамааран бүртгэлийн мэдээлэл, үйлчилгээг цахим хэлбэрээр чирэгдэлгүйгээр, шуурхай авах нөхцөл бүрдэнэ.

5.1.2. Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн хэрэглээ нэмэгдэж, цаасан суурьтай бичиг баримтын тоо буурна.

5.1.3. Бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмж чанар, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд бодит нөлөө үзүүлнэ.

5.1.4. Бүртгэлийн үйлчилгээг хүн бүр тэгш хүртэх нөхцөл бүрдэнэ.



5.1.5. Үйлчилгээний хүртээмж сайжирч, иргэд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн баталгааг хангана.

5.2. Хөтөлбөрийн эдийн засгийн үр нөлөө:

5.2.1. Төрийн байгууллагын мэдээллийн чанар сайжирч, үйлчилгээний шат дамжлага багасна.

5.2.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бүрдүүлэх баримт бичгийн тоо цөөрч, цаг хугацаа, зардал хэмнэгдэнэ.

5.2.3. Бүртгэлийн байгууллагад биеэр ирэх иргэдийн тоо багасч, автозамын түгжрэл, агаарын бохирдол буурна.

5.3. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

Д/д	Хөтөлбөрийн зорилго, зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2018 он	Зорилтот түвшин	
				Он	Үзүүлэлт
Үр нөлөөний шалгуур үзүүлэлт					
Зорилго	Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, эх нотлох баримтыг бүрэн цахимжуулж, үндэсний аюулгүй байдлыг ханган төрийн ой санамжийг бэхжүүлж, улс орны эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэн цахим хэрэглээг нэмэгдүүлэх	Улсын бүртгэлийн үйлчилгээ авахад зарцуулах хугацаа буурсан байна.	3-14 хоног	2021	5 минут-3 хоног
		Бүртгэлийн байгууллагын үйлчилгээний шат дамжлага багасна.	100%	2021	30% буурна.
		Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бүрдүүлэх баримт бичгийн тоо цөөрнө.	100%	2021	50% буурна.
		Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зардал хэмнэгдэнэ.	100%	2021	30% буурна.
		Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой төсвийн зардал буурна.	100%	2021	20% буурна.
		Бүртгэлийн байгууллагад биеэр ирэх иргэдийн тоо багасч, автозамын түгжрэл, агаарын бохирдол буурна.	100%	2021	3-4% буурна (авто машины хувьд)

Үр дүнгийн шалгуур үзүүлэлт					
Зорилт 1	Бүртгэлийн байгууллагын системийн хэмжээнд ашиглагдаж байгаа техник болон програм хангамж, мэдээллийн санг сайжруулах	Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэл, архивын нийт 15 програм хангамжийг шинэчлэн боловсруулсан байна.	33% (5 програм боловсруулсан)	2019	60%
				2020	86.6%
				2021	100%
		Бүртгэлийн системд ашиглагдаж байгаа сервер, компьютер, тоног төхөөрөмжийн 80-аас доошгүй хувийг шинэчилсэн байна.	15%	2019	45%
				2020	90%
Зорилт 2	Архивын хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг стандартад нийцүүлэн боловсронгуй болгож, эх нотлох баримтыг бүрэн цахимжуулах	Нийслэлийн 67 хороо, хүн ам ихээр төвлөрсөн 33 сумыг улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд шат дараалалтайгаар холбосон байна.	Нийт 152 хороо, 330 сумаас 85 хороо, 29 сум холбогдсон.	2019	152 хороо
				2020	42 сум
				2021	62 сум
		Архивын байранд тавигдах шаардлагад нийцсэн зориулалтын байрны зураг төслийг гаргаж, стандарт бүхий байртай болсон байна.	0%	2019	40%
		2020	70%		
		2021	100%		
		Архивын эх нотлох баримтыг цахимжуулахад шаардагдах програм хангамж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	20%	2019	100%
		Иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн архивын эх нотлох баримтыг бүрэн цахимжуулж дуусгасан байна.	65.8% цахимжсан	2019	90%
				2020	100%
Зорилт 3	Дэд бүтцийг шинэчлэн зохион байгуулж, иргэний бичиг баримтын үйлдвэрлэх хэвлэх үйлдвэрийг өргөтгөх	Монгол Улсын иргэний үнэмлэхийн нууцлал бүхий бэлдэц, бичилтийг хийх, үндэсний энгийн цахим гадаад паспортад бичилт хийх хүчин чадалтай улсын тусгай үйлдвэрийг байгуулсан байна.	0%	2019	60%
				2020	100%
		Иргэний үнэмлэхийн бэлдцийг бэлтгэхэд шаардагдах тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл худалдан авсан байна.	0%	2019	100%



		Үндэсний цахим гадаад паспортад бичилт хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	0%	2019	100%
Зорилт 4	Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн мэдээллийн санг чанаржуулах, нэгдсэн удирдлага бүхий систем бий болгох	Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн санг боловсронгуй болгох, улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн чанарыг сайжруулсан байна.	85%	2019	100%
		Засаг захиргааны нэгжийн кодчиллол болон нэршлийг нэгдсэн стандартад оруулсан байна.	88.5% /1565 засаг захиргааны нэгж/	2019	100% /нийт 1768 засаг захиргааны нэгжтэй/
Зорилт 5	Газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн сан бий болгох	Газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн санг бий болгож, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн хаяг шинэчлэн бүртгэгдсэн байна.	0%	2019	50%
				2020	70%
				2021	100%
		Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн систем дэх газрын нэгж талбарын дугаарыг газрын кадастрын суурь мэдээллийн сантай холбож үйл ажиллагааг нь уялдуулсан байна.	20%	2019	50%
				2020	70%
				2021	100%
Улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн иргэний оршин суугаа хаягийг иргэний үнэмлэхийн цахим санах ойд бичих ажил зохион байгуулагдаж, иргэний үнэмлэхийн цахим санах ойд хаяг бичигдсэн байна.	0%	2019	20%		
		2020	50%		
		2021	100%		
Зорилт 6	Бүртгэлийн байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлж, шинэ дэвшилтэт технологийн шаардлагад нийцүүлэн хүний нөөцийг чадавхижуулах	Шинэ дэвшилтэт технологийн шаардлагад нийцүүлэн бүртгэлийн байгууллагын албан хаагчдыг мэдлэг, ур чадварыг сайжруулж, чадавхижуулсан байна.	0%	2019-2021	30 албан хаагч
		Бүртгэлийн төв, орон нутгийн нэгжийг мэргэшсэн, ур чадвар бүхий хүний нөөцөөр хангасан байна.	0%	2019-2021	1000 албан хаагч

		Мэдээллийн технологийн чиглэлийн албан хаагчдыг мэргэшүүлэх, тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бий болгосон байна.	0%	2019-2021	28 албан хаагч
Зорилт 7	Тоон гарын үсгийн цахим өгөгдлийг иргэний үнэмлэхийн цахим санах ойд суурилуулж, иргэний үнэмлэхийн хэрэглээг нэмэгдүүлэх	Шинээр хэвлэх иргэний үнэмлэхийн цахим санах ойд тоон гарын үсгийн түлхүүрийн хослолыг үүсгэх, чипийн файлын бүтэц, карт хэвлэх системийн болон РКI идэвхижүүлэх програм хангамжийг боловсруулсан байна.	80 %	2019	100%
		Иргэдэд олгогдсон иргэний үнэмлэхийн РКI апплетыг шинэчилж, 2048 бит түлхүүрийн хослолыг бичих боломжтойгоор програм хангамжийг боловсруулсан байна.	80 %	2019	100%
		Иргэний үнэмлэхийн цахим санах ойд тусгагдсан тоон гарын үсгийн мэдээллийг таних програм боловсруулсан байна.	80 %	2019	100%
		Бүртгэлийн анхан шатны нэгжээр дамжуулан иргэдэд тоон гарын үсгийг олгох ажлыг эхлүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	0.6 % /3000 иргэн/	2019 2020 2021	5% 10% 15.6% /500000 иргэн/
Зорилт 8	Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт оруулж, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй авах нөхцөлийг бүрдүүлэх	Төрийн үйлчилгээний цахим машинд 12 үйлчилгээг бүрэн гүйцэд холбоно.	9 үйлчилгээ	2019	12 үйлчилгээ
		Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн бүртгэлийг цахимаар бүртгэх системийг боловсруулж, 18 төрлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ.	-	2019-2021	18 үйлчилгээ
Зорилт 9	Иргэн, төрийн болон төрийн бус байгууллагуудтай мэдээлэл солилцох	"Төрийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам"-ын хэрэгжилтийг хангаж, бүртгэлийн байгууллага тогтмол үйлчилгээнүүдээ "Үндэсний дата" төвд програмчилж, нийлүүлсэн байна.	40%	2019	100%
		Улсын бүртгэл хөтлөхөд шаардагдах мэдээллийг төрийн болон төрийн бус байгууллагуудаас авч, үйлчилгээндээ ашиглах	-	2019 2020 2021	20% 50% 100%



Зургаа.Хөтөлбөрийн санхүүжилт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 6.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 6.1.2. гадаадын зээл, тусламж;
- 6.1.3. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, удирдлага, зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус хариуцна.

7.2. Хөтөлбөрийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн
хяналт-шинжилгээ, үнэлгээ

8.1. Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журамд заасан хугацаанд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

8.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журамд заасан хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

8.3. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай тохиолдолд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 18 сараас доошгүй хугацааны дараа хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.



8.4. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар энэ хөтөлбөрийн 8.2, 8.3 дахь хэсэгт заасан тайланг хянан үзэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

8.5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

8.6. Хөтөлбөрийн явцын болон үр дүнгийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмж нь холбогдох бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 5 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 145

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын виз олгох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 338 дугаар тогтоолыг 2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг 2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ



Засгийн газрын 2018 оны 145 дугаар
тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ВИЗ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын виз хүссэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн (цаашид “гадаадын иргэн” гэх)-д виз, визийн зөвшөөрөл олгох, визийн ангиллыг өөрчлөх, визийн Монгол Улсад байх хугацааг сунгах, визийг хүчингүй болгоход Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг мөрдөхөд энэ журам үйлчлэхгүй.

1.3. Харилцан адил байх зарчмыг баримтлан виз олгох нөхцөлийг өөрчилж болно.

Хоёр. Визийн зөвшөөрөл олгох

2.1. Дипломат, албан зэргийн бүх төрлийн болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 15.1.4-т заасан “О”, 15.1.5-д заасан “В” ангиллын 30 хүртэлх хоногийн орох зориулалтын нэг болон хоёр удаагийн энгийн зэргийн визийн зөвшөөрлийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

2.2. Энэ журмын 2.1-д зааснаас бусад визийн зөвшөөрлийг гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно.

2.3. Визийн зөвшөөрөл нь тухайн визийн зөвшөөрөл олгогдсон өдрөөс 90 хоногийн дотор хүчинтэй байна.

2.4. Уригч нь хилийн боомтод олгогдох визийн зөвшөөрөл авах хүсэлтээ гадаадын тухайн иргэнийг Монгол Улсад ирэхээс 14 хоногийн өмнө гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргана.

2.5. Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 15.1.4-т заасан “О”, 15.1.5-д заасан “В” ангиллын визийн зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

2.5.1. уригчийн албан хүсэлт;
2.5.2. цахимаар бөглөсөн мэдүүлэг;
2.5.3. гадаадын иргэний хүчин төгөлдөр паспорт буюу
паспортыг орлох баримт бичиг (цаашид “паспорт” гэх)-ийн хуулбар;

2.5.4. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний
хуулбар;

2.5.5. хураамж төлсөн баримт.

2.6. Гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны
байгууллагад Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 15.1.4,
15.1.5-д зааснаас бусад ангиллын визийн зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа
дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

2.6.1. уригчийн хүсэлт;
2.6.2. гадаадын иргэний хүчин төгөлдөр паспортын хуулбар;
2.6.3. хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулах зорилгоор ирэх
гадаадын иргэнд төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас олгосон
зөвшөөрөл;

2.6.4. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний
хуулбар;

2.6.5. гэр бүлийн гишүүд дагалдан ирэх тохиолдолд
гэрлэлтийн, төрсний, үрчлэлтийн гэрчилгээг баталгаажуулсан апостиль
гэрчилгээ буюу консулын баталгаа, шаардлагатай тохиолдолд орчуулгын
хамт.

2.7. Гадаадын иргэнийг Монгол Улсад 30 хоногоос дээш
хугацаагаар урьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Гадаадын иргэний
эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-д заасан үүрэг хүлээнэ.

2.8. Түр ирэгчийн олон удаагийн виз, визийн зөвшөөрөл хүсэхэд
энэ журмын 2.6-д зааснаас гадна уригч аж ахуйн нэгж, байгууллагатай
байгуулсан гэрээ, гаалийн бүрдүүлэлт, татварын асуудал хариуцсан төрийн
захиргааны байгууллагын тодорхойлолт зэрэг хилийн боомтоор олон удаа
нэвтрэх шаардлагатайг нотлох бичиг баримтыг бүрдүүлнэ.

2.9. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 15.1.7-д
заасан “J” ангиллын 30 хүртэл хоногийн виз мэдүүлэхэд визийн зөвшөөрөл
шаардахгүй бөгөөд Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар, өргөмжит
консулд уг визийн талаарх хүсэлтээ мэдүүлнэ.

2.10. Уригч нь мэдүүлсэн мэдүүлгийн үнэн зөвийг нотлох үүргийг
хүлээж, визийн зөвшөөрөл олгоход шаардагдах үндэслэл бүхий нэмэлт
бичиг баримтыг бүрдүүлнэ.



2.11. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын олгосон визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар болон хилийн боомт дахь гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын салбар, нэгжид цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

2.12. Виз олгох байгууллага нь Монгол Улсын харьяатаас гарсан, Монгол Улсын иргэнээс төрсөн гадаадын иргэн, тэдгээрийн гэр бүлийн гишүүнд “Н” ангиллын 90 хүртэл хоногийн нэг болон хоёр удаагийн “орох” визийг зөвшөөрөлгүйгээр олгож болно.

Гурав. Виз, визийн зориулалт, төрөл, хугацаа

3.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11.5-д заасан зориулалтын визийг дараахь гадаадын иргэнд олгоно:

3.1.1. түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд “орох”;

3.1.2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 32.1-д зааснаас бусад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн тус улсаас гараад буцаж ирэх тохиолдолд “гарах-орох”;

3.1.3. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин нэг улсаас нөгөө улсад зорчиж байгаа гадаадын иргэнд “дамжин өнгөрөх”.

3.2. Визийн хүчинтэй байх хугацаа гэдэгт орох, дамжин өнгөрөх бүх төрлийн визийн хувьд виз олгосон өдрөөс Монгол Улсын хилээр нэвтрэх хүртэлх хугацааг ойлгоно.

3.3. “Гарах-орох” визийн хүчинтэй байх хугацаа гэдэгт гадаадын иргэний Монгол Улсаас гараад буцаж ирэх хугацаа хамаарах бөгөөд энэ нь түүний гадаад улсад байх хугацааг мөн тодорхойлно.

3.4. Визийн хүчинтэй байх хугацаа:

3.4.1. нэг болон хоёр удаагийн “орох” виз 90 хоног;

3.4.2. нэг болон хоёр удаагийн “гарах-орох” виз 180 хүртэл хоног;

3.4.3. нэг болон хоёр удаагийн “дамжин өнгөрөх” виз 90 хоног;

3.4.4. түр ирэгчийн болон дамжин өнгөрөх олон удаагийн визийн хүчинтэй хугацаа нь 183 буюу 365 хоног.

3.5. Албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд олгох “гарах-орох” бүх төрлийн визийн хүчинтэй хугацаа нь оршин суух зөвшөөрлийн хугацаанаас хэтрэхгүй байна.

3.6. Визийн хуудсан дээр бичигдсэн “байх хугацаа” нь гадаадын иргэн Монгол Улсын хилээр нэвтэрснээс хойш тус улсад байх хугацааг заах бөгөөд дараахь хугацаатай байна:

3.6.1. нэг болон хоёр удаагийн орох виз 90 хүртэл хоног;

3.6.2. түр ирэгчид олгох олон удаагийн виз 30 хоног;

3.6.3. бүх төрлийн “дамжин өнгөрөх” виз 10 хүртэл хоног.

3.7. Түр ирэгч гадаадын иргэний Монгол Улсад байх хугацааны нийлбэр тухайн жилд 180 хоногоос илүүгүй байх бөгөөд түүнээс илүү хугацаагаар байх тохиолдолд оршин суух зөвшөөрөл авна.

3.8. Албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэний “орох” визэд энэхүү журмын 3.6-д заасан хугацааг заахгүй бөгөөд оршин суух зөвшөөрөл мэдүүлэх хугацааг визийн хуудасны тусгай тэмдэглэл хэсэгт бичиж болно.

3.9. Гадаадын иргэний виз нь Монгол Улсад зорчих зорилготой нийцсэн байна.

Дөрөв. Виз олгох

4.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 32.2-т заасны дагуу Монгол Улсад албан хэргээр оршин суух болон түр ирэх, хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага виз, визийн зөвшөөрөл олгоно.

4.2. Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар, өргөмжит консул нь Монгол Улсыг хавсран суугаа болон гадаад улсын бусад дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөний ноот бичгийг үндэслэн гадаадын иргэнд зохих визийг олгож болно.

4.3. Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар, өргөмжит консул байхгүй улсаас ирж байгаа гадаадын иргэнд шаардлагатай тохиолдолд олон улсын хилийн боомт дээр “орох” виз олгож болно.

4.4. Хилийн боомтод Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 32.1-д зааснаас бусад Монгол Улсад оршин суугч гадаадын иргэнд уригчийн хүсэлтийг үндэслэн “гарах-орох” виз олгож болно.



4.5. “Дамжин өнгөрөх” визийг хилийн боомт дээр тухайн гадаадын иргэний очих улсын виз, эсхүл тийзийг үндэслэн олгоно.

4.6. Аялал жуулчлалаар ирэх гадаадын иргэнд олон улсын нисэх буудал дээр Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 15.1.7-д заасан “J” ангиллын визийг олгож болно.

4.7. Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй тохиолдолд гадаадын иргэн гэрээнд зааснаас илүү хугацаагаар зорчих, оршин суух зөвшөөрөл хүсэх тохиолдолд зохих ангиллын визийг урьдчилан авсан байна.

4.8. Виз хүсэгч виз мэдүүлэхдээ визийн хураамжийг төлсөн байх шаардлагатай бөгөөд виз олгохоос татгалзсан тохиолдолд уг хураамжийг буцаан олгохгүй.

4.9. Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, өргөмжит консул, хилийн боомтод Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 15.1.1-д заасан “D” ангиллын, мөн хуулийн 32.2-т зааснаас бусад “A” ангиллын виз хүсэгч гадаадын иргэн нь мэдүүлгийн хуудас бөглөн дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

4.9.1. хүчин төгөлдөр паспорт;

4.9.2. 3.5x4.5 см хэмжээтэй 1 хувь цээж зураг;

4.9.3. гадаад улсын гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан бичиг, эсхүл гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл.

4.10. Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, өргөмжит консул, хилийн боомтод Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 15.1.7-д заасан “J” ангиллын виз хүсэгч гадаадын иргэн нь мэдүүлгийн хуудас бөглөн дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

4.10.1. хүчин төгөлдөр паспорт;

4.10.2. 3.5x4.5 см хэмжээтэй 1 хувь цээж зураг;

4.10.3. Монгол Улсад ирэх, буцах нислэг буюу галт тэрэгний тийз захиалгын хуудас;

4.10.4. Монгол Улсад зорчих хугацаанд байрлах зочид буудлын захиалгын хуудас, байрлах газрын хаяг;

4.10.5. шаардлагатай тохиолдолд хөдөлмөр эрхэлдэг, санхүүгийн чадавхитайг нотолсон бичиг баримт;



4.10.6. гадаадын иргэд бүлгээр аялах тохиолдолд эрх бүхий хүлээн авагчийн урилга болон илгээгч байгууллагын хүсэлт;

4.10.7. визийн хураамж төлсөн баримт.

4.11. Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, өргөмжит консулд энэ журмын 4.9, 4.10-т зааснаас бусад ангиллын виз хүсэгч болон хилийн боомтод энэ журмын 4.9-д зааснаас бусад ангиллын виз хүсэгч гадаадын иргэн нь мэдүүлгийн хуудас бөглөн дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

4.11.1. хүчин төгөлдөр паспорт;

4.11.2. 3.5x4.5 см хэмжээтэй 1 хувь цээж зураг;

4.11.3. виз олгох эрх бүхий байгууллагаас олгосон тохиолдолд визийн зөвшөөрөл, хувийн урилга;

4.11.4. гадаадын иргэд бүлгээр аялах тохиолдолд эрх бүхий хүлээн авагчийн урилга болон илгээгч байгууллагын хүсэлт;

4.11.5. шаардлагатай бол албан хүсэлт;

4.11.6. визийн хураамж.

4.12. Виз хүсэгч нь мэдүүлгийнхээ үнэн зөвийг нотлох үүргийг хүлээж, виз олгоход шаардагдах үндэслэл бүхий бичиг баримтыг нэмж бүрдүүлнэ.

4.13. Шаардлагатай тохиолдолд виз олгох байгууллага виз хүсэгчтэй ярилцлага хийсний үндсэн дээр виз олгох эсэхийг шийдвэрлэж болно.

4.14. Визийн мэдүүлгийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон энэ журмын холбогдох заалтыг баримтлан дараах албан тушаалтан хянан баталгаажуулна:

4.14.1. гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал эрхэлсэн газрын захирал, дэд захирал;

4.14.2. Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, консулын хэлтсийн дарга, консулын албан тушаалтан, өргөмжит консул;

4.14.3. гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, түүний эрх олгосон албан тушаалтан.



4.15. Энэ журмын 4.14-д заасан албан тушаалтан гадаадын иргэний визийн мэдүүлгийг хянан баталгаажуулсан тохиолдолд хүчин төгөлдөр паспортын тэмдэглэлгүй хуудсан дээр виз олгоно.

4.16. Визийн мэдүүлгийг хянан үзээд виз олгохоос татгалзах тохиолдолд энэ тухай мэдэгдэх хуудсыг виз мэдүүлэгчид өгнө.

4.17. Виз бүхий паспортыг үрэгдүүлсэн, солиулсан гадаадын иргэнд визийн хуудасны үнийг төлүүлэн өмнө олгосон визийг дахин олгож болно.

4.18. Гадаадын иргэнд зөвшөөрөлгүй виз олгосон, визийн хуудсанд тэмдэглэх мэдээллийг буруу тэмдэглэсэн тохиолдолд визийг хүчингүй болгож, зохих ангиллын визийг дахин олгоно. Визийн хуудасны үнийг буруутай этгээдээр төлүүлнэ.

4.19. Визийг цахим хэлбэрээр олгож болно.

Тав. Виз, визийн зөвшөөрөл олгохоос татгалзах,
визийг хүчингүй болгох

5.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд зааснаас гадна дараах үндэслэлээр виз, визийн зөвшөөрлийг олгохоос татгалзана:

5.1.1. гадаадын иргэн виз, визийн зөвшөөрөл мэдүүлэхээс өмнө 1 сарын хугацаанд Зөрчлийн тухай хуулийн 16.2-т заасан зөрчил гаргаж шийтгэл хүлээсэн;

5.1.2. Монгол Улсад зорчих зорилгоо тодорхойлж чадаагүй;
5.1.3. виз олгоход шаардагдах бичиг баримтыг гаргаж өгөөгүй;

5.1.4. хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, худал мэдүүлэг өгсөн;

5.1.5. мэдүүлгийн хуудсыг бүрэн гүйцэд бөглөөгүй.

5.2. Визийг дараахь үндэслэлээр хүчингүй болгоно:

5.2.1. визийг хуурамчаар үйлдсэн;

5.2.2. уригчийн үндэслэл бүхий хүсэлтийг харгалзан;

5.2.3. тагнуул, цагдаагийн байгууллагын бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн;

- 5.2.4. визийн хуудсан дээрх бичилт, тэмдэглэгээ алдаатай;
- 5.2.5. албадан гаргаж байгаа;
- 5.2.6. визийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй олгосон;

5.2.7. бичиг баримт хуурамчаар бүрдүүлэн виз, оршин суух зөвшөөрөл мэдүүлсэн;

5.2.8. оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгосон болон хугацаа дууссан.

5.3. Визийг хүчингүй болгохдоо визийн хуудас дээр “хүчингүй” буюу “void” тэмдэг дарна.

5.4. Виз, визийн зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд виз, визийн зөвшөөрөл хүсэгч 30 хоногийн дараа дахин хүсэлт гаргаж болно.

Зургаа. Монгол Улсад байх визийн хугацааг
сунгах, ангилал өөрчлөх

6.1. Визийн хүчинтэй хугацааг сунгахгүй.

6.2. Гадаадын иргэн Монгол Улсад байх визийн хугацааг сунгуулах хүсэлтээ мэдүүлгийн хуудас бөглөн дараах бичиг баримтын хамт уг хугацаа дуусахаас ажлын 4-өөс доошгүй хоногийн өмнө Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 16.1.1, 16.1.2-т заасан эрх бүхий байгууллагад гаргана:

- 6.2.1. хүчин төгөлдөр паспорт;
- 6.2.2. уригчтай бол уригчийн хүсэлт;
- 6.2.3. 3.5x4.5 см хэмжээтэй 1 хувь цээж зураг.

6.3. Түр ирэгч гадаадын иргэний визийн сунгалт хоорондын хугацаа 90 хоногоос доошгүй байна.

6.4. Төрийн болон Засгийн газар хоорондын байгууллагын шугамаар ирсэн гадаадын иргэний визийн хугацааг сунгахад энэ журмын 6.3 дахь хэсэг хамаарахгүй.

6.5. Хөрөнгө оруулагч, төрийн болон Засгийн газар хоорондын байгууллагад ажиллахаар ирсэн, Монгол Улсын харьяатаас гарсан, Монгол Улсын иргэнээс төрсөн гадаадын иргэн болон тэдгээрийн гэр бүлийн гишүүн түр ирэгч оршин суух зөвшөөрөл хүссэн тохиолдолд визийн ангиллыг өөрчилж болно.



6.6. Гадаадын иргэн оршин суух зөвшөөрлийн хэлбэрээ өөрчлөх хүсэлт гаргасан тохиолдолд визийн ангиллыг нь өөрчилнө.

6.7. Визийн ангиллыг өөрчлөхдөө оршин суух зөвшөөрлийн хэлбэрт нийцүүлэн визийг дахин олгоно.

6.8. Монгол Улсад байх визийн хугацааг сунгахдаа бүртгэл хийн, паспортад “бүртгэв” гэсэн тэмдэг дарна. “Бүртгэв” тэмдэгт гадаадын иргэнийг бүртгэсэн он, сар, өдрийг бичиж, тэмдэгний хажууд бүртгэлийн дугаарыг тэмдэглэнэ.

6.9. Монгол Улсад байх визийн хугацааг сунгах хоногийг “хасав” гэсэн тэмдгийн зүүн доод буланд бичнэ. “Хасав” тэмдгийн “он, сар, өдөр” гэсэн хэсэгт визийн сунгалтын сүүлийн өдрийг бичиж, тэмдгийн хажууд сунгасан визийн дугаарыг тэмдэглэнэ.

Долоо. Бусад зүйл

7.1. Зөрчлийн тухай хуулийн 16.2-т заасны дагуу захиргааны шийтгэл оногдуулсан гадаадын иргэний паспортад гарах хугацааг заасан “хасав” тэмдгийг дарна.

7.2. Энэ журмын 7.1-д заасан хасалт нь захиргааны шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 10 хүртэл хоногийн хугацаатай байна. Гадаадын иргэн нь уг хугацаанд багтаж Монгол Улсаас гарах үүрэгтэй.

7.3. Гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бүртгэх, хасалт хийх, хүчингүй болгох тэмдгийн загварыг тус тус баталж, загварыг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

7.4. Шаардлагатай тохиолдолд виз, визийн зөвшөөрөл олгохдоо хууль хяналтын байгууллагын саналыг авна.

7.5. Гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь виз, визийн зөвшөөрөл олгох, сунгах хүсэлтийг ажлын тав хоногт, яаралтай бол ажлын гурав хоногт багтаан шийдвэрлэнэ.

7.6. Виз, визийн зөвшөөрөл хүсэгч мэдүүлгийн хуудас, бичиг баримтыг бүрэн гүйцэт, үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй.

7.7. Хүчин төгөлдөр визтэй гадаад паспортын хуудас дууссан (тэмдэглэгээ хийх зайгүй болсон), хүчингүй болсон зэргээр ашиглах боломжгүй болсон паспортыг шинэ паспортын хамт авч яваа тохиолдолд виз шилжүүлэхийг шаардахгүй.



7.8. Виз олгох эрх бүхий байгууллага виз, визийн зөвшөөрөл олгох хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч болно.

7.9. Визийн мэдүүлгийн хуудасны загварыг хууль зүй болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

7.10. Виз, визийн зөвшөөрөл мэдүүлэхэд гадаадын иргэний паспортын хүчинтэй хугацаа 6 сараас дээш байна.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018 оны 8 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 15.30 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Цэцийн гишүүн Н.Чинбат, Д.Солонго /илтгэгч/, Б.Буяндэлгэр, Г.Туулхүү нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Ц.Долормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч, иргэн С.Мөнхцэцэг, мэдээлэл гаргагч, иргэн Б.Оюу, А.Гулим болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Хэнтий аймгийн Баянхутаг сумын 2 дугаар багийн оршин суугч, иргэн С.Мөнхцэцэг Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:



“... Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоолын 1, 2 дахь заалтаар Хэнтий аймгийн 42 дугаар тойрогт нөхөн сонгуулийг 2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс товлон зарлаж, санал авах өдрийг мөн оны 10 дугаар сарын 7-ны өдрөөр тогтоосон ба мөн тогтоолын 3 дахь заалтаар тогтоолын хэрэгжих хугацааг заасан байна.

Миний бие төрийн жинхэнэ албан хаагч бөгөөд Үндсэн хуульд заасан төрийн байгууллагад сонгогдох эрхийн дагуу энэхүү нөхөн сонгуульд нэр дэвшихээр шийдээд байгаа юм. Нөхөн сонгуулийг Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “... энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурал товлон зарлах”-аар зохицуулсан байна.

Үндсэн хууль болон Сонгуулийн тухай хуульд Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг 4 жил тутам явагдахаар цаг хугацааг нь тодорхой заасан бөгөөд иргэн хүн сонгуульд нэр дэвших эсэхээ эртнээс шийдэж, хуулиар тогтоосон шаардлагыг ханган оролцох боломжтой байдаг. Харин нөхөн сонгууль нь Сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 болон 137 дугаар зүйлийн 137.6 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдсөн, гишүүнийг эгүүлэн татсан, гишүүн нас барсан тохиолдолд орон гарсан суудлыг нөхөх зорилгоор явагдах бөгөөд нөхөн сонгууль явагдах эсэхийг урьдчилан тааж мэдэх ямар ч боломжгүй байдаг болно. Гэтэл энэ удаа нөхөн сонгууль зарлахад Сонгуулийн тухай хуульд нэгэнт товлон зарласан нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагчдыг хэрхэн оролцуулах тухай зохицуулалт огт тусгагдаагүй хийдэл үүссэн байна.

Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт “Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал нь Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлтээ эрх бүхий этгээдэд гаргасан байх ба сонгуулийн жилийн нэгдүгээр сарын 31-ээс хойш ажил, албан үүргээ гүйцэтгээгүй байна.” Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт “Төрийн жинхэнэ албан хаагч Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвших бол тухайн ээлжит сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө ... төрийн албанаас чөлөөлөгдөх өргөдлөө төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд гаргана. ... Сонгуульд нэр дэвшихтэй холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагч өргөдлөө гаргаагүй нь тухайн төрийн байгууллага түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй.” гэж тус тус заасан.

Дээрх хуулиудын зохицуулалтаас үзэхэд ээлжит сонгуульд нэр дэвших төрийн жинхэнэ албан хаагч нь "... сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө ...", "... тухайн ээлжит сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө ..." гэж төрийн албанаас чөлөөлөгдсөн байх хугацааг тодорхой заасан байна. Гэтэл нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагчид хэзээ, хэрхэн ажлаасаа чөлөөлөгдөн оролцох зохицуулалтыг орхигдуулснаас төрийн байгууллагад ажиллаж буй төрийн жинхэнэ албан хаагчид нөхөн сонгуульд оролцохын тулд одоо ажлаасаа чөлөөлөгдөхөд дээр дурдсан хугацааны шаардлагыг хангаж чадахгүй тул сонгуульд оролцох боломжгүй болж байна. ...

Иймд төрөөс Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчдыг нөхөн сонгуульд оролцох зохицуулалтыг тодорхой болгосны үндсэн дээр тус нөхөн сонгуулийг зарлах нь Үндсэн хуульд нийцэх бөгөөд улмаар төрийн жинхэнэ албан хаагчид Үндсэн хуулиар олгогдсон сонгогдох эрхээ эдлэх хууль зүйн баталгаа бүрдэх юм.

Ийнхүү төрийн жинхэнэ албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгаа бүрдээгүй байхад нөхөн сонгууль болсон тохиолдолд нэр дэвших хүсэлт гаргасан боловч дээр дурдсан шаардлагыг хангаагүй үндэслэлээр сонгуульд оролцож чадаагүй төрийн албан хаагчид өргөдөл, мэдээлэл гаргасны улмаас нөхөн сонгууль бүхэлдээ хүчингүйд тооцогдож, дахин сонгууль болох улмаар үр дүнгүй их хэмжээний зардал гарч, ул орны эдийн засагт хохирол учруулах нөхцөл байдал бий болохыг үгүйсгэх аргагүй.

Энэ бүхний эцэст төрийн жинхэнэ албан хаагчид бид аливаа сонгууль болохоос өмнө хуулиар тогтоосон боломжит хугацаанд албан тушаалаасаа чөлөөлөгдөж, сонгуульд нэр дэвшиж, Үндсэн хуульд заасан сонгогдох эрхээ эдлэх хүсэлтэй байна. Тиймээс нөхөн сонгуульд төрийн албан хаагчид хэрхэн, яаж оролцохыг хуулиар тодорхой зохицуулсны дараа нөхөн сонгуулийг зарлах нь хууль дээдлэх ёс, эрх зүйт төрийн зарчим, үндсэн хуульт ёсонд нийцнэ. Үүний зэрэгцээ Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол дараахь байдлаар Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна:

1. Төрийн албан хаагчдыг нөхөн сонгуульд оролцуулах хуулийн зохицуулалтыг орхигдуулж, хууль зүйн баталгаа хангах үүргээ төр биелүүлээгүй байхад нөхөн сонгууль зарласан нь төрийн жинхэнэ албан хаагчдыг нөхөн сонгуульд оролцох боломжгүй болгож, улмаар иргэн хүн сонгогдох эрхээ эдлэхэд тэгш бус шаардлага тавьж байгаа нь Үндсэн



хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчиж байна.

2. Төрийн жинхэнэ албанд ажилласных нь төлөө иргэнд хуулиар биелүүлэх боломжгүй шаардлага тавьж, сонгогдох эрхийг хязгаарлаж байгаа нь Үндсэн хуулийн суурь зарчмыг үгүйсгэж, улмаар хүнийг эрхэлж буй ажил, албан тушаалынх нь хувьд шууд ялгаварлан гадуурхсан гэж үзэхээр байгаа ба энэ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэж заасныг зөрчөөд байна.

3. Сонгуулийн тухай хуульд нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагч хэрхэн оролцох талаар зохицуулалтыг тодорхой тусгаагүй орхигдуулсан ба албан тушаалаасаа чөлөөлөгдөх хуулийн шаардлага нь нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагчийг нэр дэвшүүлэх боломжгүй болгож, тэгш бус нөхцөлийг тулгаж, улмаар иргэний төрийн байгууллагад сонгогдох эрхийг ноцтойгоор зөрчиж байна. Түүнчлэн иргэний төрийн байгууллагад сонгогдох эрхийн хууль зүйн баталгааг төрөөс бүрэн хангаагүй байхад нөхөн сонгуулийг товлон зарласан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэж заасныг зөрчиж байна.

4. Улсын Их Хурлаас баталсан хууль нь Үндсэн хуульд заасан төрийн байгууллагад сонгогдох эрхийг бүрэн хангахад чиглэсэн баталгаа болохуйц байх ёстой. Хууль тогтоогчийн зүгээс Сонгуулийн тухай хуульд төрийн жинхэнэ албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргээ биелүүлээгүй, зохицуулалтыг орхигдуулсан буюу төрийн жинхэнэ албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгаа хангагдаагүй байхад Улсын Их Хурлын 62 дугаар тогтоолоор нөхөн сонгуулийн тов зарлаж, санал авах өдрийг тогтоосон, мөн төрийн алба улс төрөөс ангид байх зарчмыг хэрэгжүүлэх зохицуулалт тодорхойгүй, ойлгомжгүй байгаа нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...” гэж заасан үүргээ зөрчсөн гэж үзэхээр байна.

5. Сонгуулийн тухай хуулиар нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагч оролцох эрхийн хууль зүйн баталгааг бүрэн хангаагүй атал Сонгуулийн ерөнхий хороо төрийн жинхэнэ албан хаагчийг нэр дэвшигчид тавигдах шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр бүртгэхээс татгалзах шийдвэр гаргах нөхцөл байдал үүсч, улмаар Үндсэн хуульд заасан хэзээ ч хязгаарлаж үл болох иргэний баталгаатай эдлэх улс төрийн эрхийг

хязгаарлаж Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчсөн шийдвэр болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж тус тус заасныг зөрчсөн байх тул хянан хэлэлцэж, дүгнэлт гаргаж өгнө үү.” гээд өргөдлийн үндэслэлээ баталгаажуулан хавсарган ирүүлсэн баримтад:

Иргэн С.Мөнхцэцэгийн Сонгуулийн ерөнхий хороонд хандаж Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд (2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс товлон зарласан) нэрээ дэвшүүлэх хүсэлтэй төрийн албан хаагч эрхэлж буй ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ хэзээ гаргаж, хэзээ чөлөөлөгдсөн байх шаардлагатай талаар тодруулга хүсэхэд, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албанаас 2018 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 66 дугаар албан бичгээр “Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсгийн зохицуулалтыг тусгаад Сонгуулийн төв байгууллагын хувьд хуулийг баримтлан ажиллах бөгөөд хууль тогтоомжийг тайлбарлах эрх хэмжээ тус байгууллагад олгогдоогүй тул тайлбар, тодруулга өгөх боломжгүй юм.” гэсэн хариуг өгсөн байна.

Хоёр. Нийслэлийн Баянгол дүүргийн 3 дугаар хороонд оршин суугч, иргэн Э.Эрдэнэцэцэг, Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хороонд оршин суугч, иргэн Б.Оюу, Баянзүрх дүүргийн 25 дугаар хороонд оршин суугч, иргэн А.Гулим нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“Улсын Их Хурлаас 2018 оны 62 дугаар тогтоол гарснаар төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирлын албан тушаал эрхэлж байгаа иргэд Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцох боломжгүй болоод байна. Учир нь Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт дурдсан төрийн албан



хаагчид Сонгуулийн тухай хуульд заасан нэр дэвшигчид тавигдах нийтлэг шаардлагаас гадна нөхөн сонгуульд нэрээ дэвшүүлэхийн тулд сонгуулийн жил буюу 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө албан тушаалаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлтээ өгч, 1 дүгээр сарын 31-ний өдрөөс хойш албан үүргээ гүйцэтгэхгүй байх нэмэлт шаардлага тавьсан нь одоо ажлаа эрхэлж буй албан хаагч нь энэхүү шаардлагыг хангаагүй гэдэг үндэслэлээр нэр дэвшигчээр бүртгэхгүй байх улмаар Үндсэн хуульд заасан төрийн байгууллагад сонгогдох эрх зөрчигдөхөөр байна.

Нөхөн сонгууль нь Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдсөн, гишүүнийг эгүүлэн татсан, гишүүн нас барсан тохиолдолд орон гарсан суудлыг нөхөх зорилгоор явагдах бөгөөд Сонгуулийн тухай хуулиар дээр дурдсан албан хаагчийг нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгааг бүрдүүлээгүй байна. ... Ийнхүү дээр дурдсан төрийн албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгаа хангагдаагүй байхад Улсын Их Хурлаас 62 дугаар тогтоол гаргаж, нөхөн сонгуулийг зарлан иргэний төрийн байгууллагад сонгогдох эрх төрийн байгууллагын буруугаас зөрчигдөхөд хүргэж, улмаар төрийн албанд ажилласны төлөө нэрээ дэвшүүлэх эрхийг бүрмөсөн хязгаарлаж байгаа нь улс төрийн сонгуульд нэр дэвшигчид ижил тэнцүү нөхцөлд, шударгаар өрсөлдөх боломжийг бүрдүүлэх бус харин эсрэгээрээ Үндсэн хуулийн үндсэн зарчмыг үгүйсгэсэн Үндсэн хуулийн зөрчил юм. ...

Иймд Сонгуулийн тухай хуулиар дээр дурдсан төрийн албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгаа бүрэн хангагдаагүй байхад баталсан Улсын Их Хурлын 62 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэсэн заалтыг зөрчсөн, Үндсэн хуульд нийцээгүй шийдвэр болсон гэж үзэж байна.” гэжээ.

Гурав. Уг маргаанд холбогдуулан Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцангаас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн харуу тайлбартаа:

“Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоолыг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 20 дугаар

зүйлийн 20.1 дэх хэсгийг үндэслэн баталсан. Уг тогтоол нөхөн сонгуулийг эхлэх өдөр болон санал авах ажиллагааг явуулах өдрийг тогтоосон хоёр заалттай бөгөөд тухайн сонгуульд нэр дэвшүүлэхэд тавигдах шаардлагын талаар тусгайлан зааж төрийн албан хаагчийн эрхийг хязгаарласан заалт уг тогтоолд байхгүй юм.

Иргэдийн өргөдөл, мэдээлэлд дурдсан Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт төрийн албан хаагч сонгуульд нэр дэвшүүлэхэд тавигдах шаардлагыг заахдаа "... Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө ..." гэж заасан бөгөөд "сонгуулийн жил" гэсэн нэр томъёог хэрэглэсэн байна.

"Сонгуулийн жил" гэж мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад зааснаар дөрвөн жил тутам явагдах ээлжит сонгуулийн жилийг ойлгоно. Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт зааснаар сонгууль нь ээлжит, ээлжит бус, нөхөн, дахин гэсэн төрлүүдтэй байх бөгөөд "Ээлжит сонгууль гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2, Гучдугаар зүйлийн 2, Тавин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт тус тус заасны дагуу дөрвөн жил тутам явагдах сонгуулийг хэлнэ." гэж заажээ. Одоо бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Улсын Их Хурал нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан дөрвөн жил тутам явагдах сонгуулийн үр дүнд байгуулагдсан бөгөөд 2016 онд явагдсан энэхүү сонгууль нь Сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад заасан ээлжит сонгууль юм. Харин Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт товлон зарласан сонгууль нь Сонгуулийн тухай хуулийн мөн зүйлийн 8.1.3 дахь заалтад заасан нөхөн сонгууль билээ. Эндээс үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт заасан "сонгуулийн жил" гэдэгт дөрвөн жил тутам явагдах ээлжит сонгуулийн жилийг ойлгох бөгөөд "сонгууль явуулах тухайн жил" гэсэн ойлголтыг агуулаагүй байгаа тул төрийн албанаас чөлөөлөгдөх шаардлагад заасан хугацаа нь Улсын Их Хурлын нөхөн сонгуульд нэр дэвшүүлэхэд хамаарахгүй юм.

Түүнчлэн Сонгуулийн тухай хууль батлагдсанаар хүчингүйд тооцогдсон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт "Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна." гэж заасан нь одоогийн хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт заасантай хугацааны хувьд ижил шаардлага тавьж



байсан бөгөөд уг заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг Үндсэн хуулийн цэцээс өмнө нь хянан шийдвэрлэж 2015 оны 12 дугаар дүгнэлт болон мөн оны 10 дугаар тогтоолыг баталсан байна.

Үндсэн хуулийн цэцийн дээрх шийдвэрт “...Төрийн жинхэнэ буюу мэргэшсэн алба хаагчдыг ажил, мэргэжлийн онцлог, хэрэгжүүлэх чиг үүргийг харгалзан улс төрийн үйл ажиллагаанаас ангид байлгах, төвийг сахисан байр суурийг хадгалахад чиглэсэн тусгай шаардлага, шалгуурыг тэдэнд тавьж холбогдох хуулиар зохицуулах нь хууль тогтоогчийн бүрэн эрхийн асуудал юм. ... Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, ... үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэсэн заалтыг тус тус зөрчөөгүй байна.” гэж дурдсанаас үзэхэд сонгуульд нэр дэвших төрийн албан хаагчийн төрийн албанаас чөлөөлөгдөх хугацааны шаардлагыг Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад “Улсын Их Хурал ... Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гэж, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурал товлон зарлана.” гэж, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургадугаар сарын сүүлийн Ням гараг болон аравдугаар сарын эхний Ням гараг байх ба улс даяар нэгдсэн журмаар явагдана.” гэж, мөн хуулийн 137 дугаар зүйлийн 137.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний орон гарсан бол нөхөн сонгууль явагдана.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд 2018 оны 62 дугаар тогтоолыг баталж, нөхөн сонгуулийг товлон зарласан бөгөөд уг тогтоолд төрийн албан хаагчдын сонгуульд нэр дэвших харилцаатай холбоотой аливаа зохицуулалт байхгүй болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчөөгүй болно.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурал 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан өөрийн бүрэн эрхийн хүрээнд 62 дугаар тогтоол батлан гаргаж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгууль товлон зарлаж, санал авах өдрийг тогтоосон байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” хэмээн Монгол Улсын иргэн төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хуралд сонгогдох эрхтэй болохыг нийтлэг байдлаар хуульчилсан байна. Мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хүлээхээр зааж, Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.” гэжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтын дагуу Улсын Их Хурал 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Сонгуулийн тухай хуулийг баталж, тус хуулиар Монгол Улсын Их Хурлын болон бусад байгууллагын сонгуулийн үндсэн зарчим, журмыг тодорхойлж, сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах хэм хэмжээг тогтоожээ.

Сонгуулийн тухай энэхүү хуулиар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан иргэдийн өргөдөл, мэдээлэлд дурдсан нөхцөл байдал буюу нөхөн сонгууль товлон зарлагдсан тохиолдолд тухайн сонгуульд нэр дэвших, улмаар төрийн байгууллагад сонгогдох эрхийг хэрэгжүүлэх хууль зүйн боломжийг хууль тогтоогч бүрэн бүрдүүлээгүй гэж үзэхээр байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон Сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан дөрвөн жил тутам явагдах Улсын Их Хурлын ээлжит сонгуульд төрийн албанд ажиллаж буй иргэд нэрээ дэвшүүлэх, эсхүл нэр дэвших тохиолдолд Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт заасан хугацааны дотор ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ гаргахыг тодорхой заажээ.

Харин Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд нэрээ дэвшүүлэхийг хүссэн төрийн албанд ажиллаж байгаа иргэд тухайн сонгуулийн санал хураалт болох өдрөөс хэдий хугацааны өмнө ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргах, чөлөөлөгдсөн байх талаарх зохицуулалтыг Сонгуулийн тухай хуульд тусгаагүй байна.



Сонгуулийн тухай хуулийн 128 дугаар зүйлд Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийг бүртгэх талаарх нийтлэг зохицуулалтыг хуульчлахдаа тус зүйлийн 128.2.7, 128.3.6 дахь заалтад “төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлт, ажил албан тушаалаас чөлөөлөх тухай шийдвэрийн тус тус нотариатаар батлуулсан хуулбар,” зэргийг нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш гурав хоногт багтаан сонгуулийн төв байгууллагад ирүүлэхээр заасан байна. Түүнчлэн тус хуулийн 129 дүгээр зүйлийн 129.1.2 дахь заалтад “нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй;”, 129.1.5 дахь заалтад “нэр дэвшигчийг бүртгүүлэхэд шаардагдах энэ хуульд заасан баримт бичиг дутуу ...” зэрэг шаардлагыг хангаагүй бол нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзахаар зохицуулжээ.

Үүнээс үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.2.7, 128.3.6 дахь заалтад хамаарах иргэдийн хувьд нөхөн сонгуульд санал авах өдрөөс хэдий хугацааны өмнө ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байх зохицуулалтыг хуульд тусгаагүйн улмаас энэ шаардлагыг урьдчилан хангах хууль зүйн боломж бүрдээгүй байна. Ингэснээр иргэд уг сонгуульд нэрээ дэвшүүлж чадахгүйд хүрч, улмаар тэдний хувьд тэгш бус байдал буюу эрхэлсэн ажил, албан тушаалаасаа хамааран ялгаварлагдах хууль зүйн үндэслэл бий болохын хамт нөхөн сонгуульд оролцож сонгогдох эрхээ хэрэгжүүлж чадахгүй нөхцөл байдал үүсжээ. Иймд сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох тулгамдсан асуудал байгааг дурдах нь зүйтэй юм.

3. Хууль тогтоогч Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг товлон зарлах шийдвэрийг гаргахдаа Үндсэн хуульт ёс, ардчилсан эрх зүйт төрийн суурь үзэл баримтлал, иргэний улс төрийн эрхийн хязгаарлалтын талаарх нийтээр хүлээн зөвшөөрсөн түгээмэл зарчимд нийцүүлэн Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийнхээ дагуу тухайн сонгуульд оролцох иргэдийн эрх зүйн байдлыг тогтоох ёстой атал иргэдэд тэгш бус байдлыг бий болгосон сонгуулийн хууль тогтоомжийн хийдлийг арилгахгүйгээр 2018 оны 62 дугаар тогтоолыг баталжээ.

Уг тогтоолыг болон Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн зардлыг хэлэлцэн баталсан Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, түүнчлэн чуулганы нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлтэй танилцахад холбогдох хуралдаан дээр нөхөн сонгууль товлон зарлагдсан

тохиолдолд төрийн албанд ажиллаж буй иргэдийн сонгогдох эрх хязгаарлагдаж, тэгш бус байдал үүсэх эрх зүйн нөхцөл бүрдэж байгаа талаар яригдаж байсан нь нотлогдож байна.

Иймд Монгол Улсын Их Хурал 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол батлан гаргаснаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчиж, улмаар Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэж заасан нь зөрчигдөх нөхцөл бүрдсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр батлан гаргасан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчсөн байна.



2. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоолыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Д.ОДБАЯР

ГИШҮҮД

**Н.ЧИНБАТ
Д.СОЛОНГО
Б.БУЯНДЭЛГЭР
Г.ТУУЛХҮҮ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.25

Индекс: 200003